

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын нэгдүгээр газар

Газрын захирал

Ц.Батбаяр

Аудитын менежер

Ж.Батсайхан

Ахлах аудитор

А.Сүхбаатар

Аудитор Д.Гандолгор

Шинжээч Б.Саруул

Ш.Энхтайван

2009 оны 6 дугаар сар

Уг тайланг ҮАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.

www.mnao.pmis.gov.mn

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261805 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
210642 Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6,
Улаанбаатар-46
Монгол Улс

Товчилсон үгийн тайлбар4

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5

Бүлэг 1

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тусгахгүй байна

- Хууль, хүчний байгууллагуудад хөрөнгө оруулалтын стратеги төлөвлөгөө боловсруулах ажил харилцан адилгүй хийгдсэн байна.....6
- Салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрүүдийг зохицуулсан нэгдсэн бодлого алга байна.....8
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зарим барилга байгууламжийн зураг, төсвийг тухайн онд нь хийж эхлэхээр тусгасан байна.....10

Бүлэг 2

Гүйцэтгэгчийг шалгаруулахдаа хууль зөрчиж байна

- Зарим байгууллага худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөө нийтэд мэдээлээгүй байна.....11
- Төрийн нууцын тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагаанд шууд гэрээ байгуулсан байна 1
- Худалдан авах ажиллагааны тайланд тайлбар, нотолгоог дутуу тусгаж байна.....

Бүлэг 3

Зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хуурамчаар гаргаж санхүүжүүлжээ

- 2008 онд Батлан хамгаалах болон хууль, хүчний байгууллагын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 72.0 хувийг улсын төсвийн болон МУХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлжээ
- Улсын комисс хүлээн аваагүй барилгыг ашиглаж байна
- Улсын архивын нэгдсэн барилгын ажлыг эхлээгүй байна19

Бүлэг 4

Хяналт тавьж, санхүүжилт олгодог албадын ажлын уялдаа хангалтгүй байна

- Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн дийлэнхийг 11, 12 дугаар сард олгожээ
- ТЕЗ-дын санхүү, ар талын газар, Хөрөнгө оруулалт барилга захиалагчдын албад хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт тавьсан байна

- Хөрөнгө оруулалтын удирдлага, санхүүжилтийн асуудлыг боловсронгуй болгох шаардлагатай байна

Дүгнэлт.....24

Холбогдох байгууллагын санал.....

Тайлбар.....

Зөвлөмж.....25

Хавсралтууд

Хавсралт №1

Хавсралт №2

Хавсралт №3

Хавсралт №4

Хавсралт №5

Товчилсон үгийн тайлбар

АТГ	Авлигатай тэмцэх газар
АЕГ	Архивын ерөнхий газар
БХЯ	Батлан хамгаалах яам
БХС	Батлан хамгаалахын сайд
ГИХАЭГ	Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх газар
МУХС	Монгол Улсыг хөгжүүлэх сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ТТАХНЭ	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
УДШ	Улсын Дээд Шүүх
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ШШҮХ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1.1 Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2009 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаадын зээл, тусламж, өөрийн хөрөнгө, урсгал зардал, бусад хөрөнгөөр 2008 онд батлан хамгаалах, хууль, хүчний байгууллагуудад хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ.

- Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт, түүний үндэслэл, үр нөлөө
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгох ажиллагаа, түүний зохион байгуулалт, үр нөлөө
- Захиалагчийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний гүйцэтгэлийг үнэлэх, хариуцлага тооцох үйл явцын хэрэгжилт, түүний үр нөлөө
- Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, хяналтын үйл ажиллагааны удирдлага, санхүүжилтийн тогтолцоо оновчтой, үр ашигтай, үр нөлөөтэй зохион байгуулагдсан эсэх

Аудитад БХЯ, түүний харъяа цэргийн анги, нэгтгэлүүд, ХЗДХЯ, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд харьяалагдах ЦЕГ, ШШГЕГ, ХХЕГ, АЕГ, ГИХАЭГ, ШШҮХ, ТТАХНЭ зэрэг агентлаг, байгууллагууд, АТГ, УЕПГ, УДШ-ийн Ерөнхий шүүгч, ШЕЗ тус тус хамрагдав.

Эдгээр байгууллагад Сангийн яамнаас олгосон хөрөнгө оруулалтын санхүүжилтийн баримт, дансны хуулга, 2008 оны санхүүгийн тайлан, худалдан авах үйл ажиллагааны тайлан, баригдсан барилга байгууламж, худалдан авсан машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлийг хүлээн авсан, данс бүртгэлд тусгасан журнал, тайлан, бусад холбогдох баримт материалыг шалгав.

Аудитын явцад улс, орон нутгийн төсөв, МУХС, зээл, тусламж, өөрийн хөрөнгө, урсгал зардал, бусад хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, түүнийг зохион байгуулсан, хэрэгжүүлсэн, данс бүртгэлд тусгасан байдалд хийсэн судалгааг байгууллага бүрээр гаргуулан нэгтгэсэн болно.

1.3 Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хууль,
- Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль,
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль,
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,
- Төрийн нууцын тухай хууль,
- Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого
- Батлан хамгаалах, хуулийн байгууллагуудын хөгжлийн стратеги, бодлогууд
- Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох бусад хууль, тогтоомж

Аудитыг Үндэсний аудитын газрын Нэгдүгээр газрын захирал Ц.Батбаяр, Аудитын менежер Ж.Батсайхан нар удирдан, аудитын явцад хяналт тавьж, Хуулийн байгууллагуудын багийн ахлах аудитор А.Сүхбаатар, аудитор Д.Гандолгор, шинжээч Б.Саруул, Ш.Энхтайван нар 2009 оны 4 дугаар сарын 27-ноос 6 дугаар сарын 2-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Батлан хамгаалах болон хуулийн байгууллагуудад орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн үр дүнд аймаг, нийслэлийн аудитын газрууд аудит хийсэн болно.

Бүлэг 1

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тусгахгүй байна

1.1 Хууль, хүчний байгууллагуудад хөрөнгө оруулалтын стратеги төлөвлөгөө боловсруулах ажил харилцан адилгүй хийгдсэн байна

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод үндэслэн боловсруулсан Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хуулийн болон батлан хамгаалах байгууллагын хөрөнгө оруулалтын бодлогыг байгууллага бүрийн онцлогоор нарийвчлан тусгасан байна.

Тухайлбал, цогц бодлогын 7.4.2-т “цагдаа, тагнуул, шүүх, прокурор гэх мэт байгууллагууд хүний үндсэн эрхийг зөрчихгүйгээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг сахиулах үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, иргэдийг төрийн хууль ёсыг хүндэтгэдэг, нийгмийн дэг журмыг сахин биелүүлдэг, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагааг ойлгодог, дэмждэг, хамтран ажилладаг байх нөхцлийг бүрдүүлэх” гэж хуулийн байгууллагуудын хэтийн зорилтыг тодорхойлжээ.

Дээрх цогц бодлогын 7.6-д “Монгол Улсын төрөөс дотоод, гадаад улс төрийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхдээ улс орны батлан хамгаалах чадамж бэхжүүлэх үйл хэргийг анхаарлын төвд байлгаж, Зэвсэгт хүчний ерөнхий удирдлага, иргэний хяналтын үр дүнтэй тогтолцоог бий болгоно”, “Орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэн бэхжүүлнэ”, “батлан хамгаалах нөөцийн менежментийг боловсронгуй болгох хүрээнд зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийн орчин үеийн шаардлагад нийцүүлэн үе шаттайгаар шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор тусламж, хандив болон төсвийн дэмжлэгтэйгээр “Зэвсэгт хүчний хөгжлийн сан” бий болгох” гэж батлан хамгаалах салбарын хэтийн зорилтыг тодорхойлсон байна.

ХЗДХС-ын эрхлэх асуудлын хүрээнд багтдаг агентлаг, байгууллагууд Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй уялдуулсан хөгжлийн урт хугацааны стратеги төлөвлөгөө, нэгдсэн бодлого боловсруулсан боловч албан ёсоор баталгаажуулаагүй байна.

Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөгөөгүй байна.


Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 304 дүгээр зарлигаар баталсан Зэвсэгт хүчний байгууллагыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийн дагуу жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж байна. Энэхүү хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 1 дүгээр шат нь 2006-2010 оныг хамрах бөгөөд Зэвсэгт хүчний байгууллагын эрх зүйн болон материаллаг баазыг хангах, 2 дугаар шат нь 2011-2015 оныг хамрах ба Зэвсэгт хүчний байгууллагыг хөгжүүлэх зорилтыг хангах юм.

ХЗДХС-ын 2008 оны төсвийн багцын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд цагдаагийн байгууллагын шаардлагатай автомашиныг шинэчлэх асуудлыг цогцоор шийдэх, хоригдлыг нийгэмшүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, ялтны амьдрах нөхцөл, хамгаалалтыг сайжруулах, хил хамгаалалтад шинэ техник технологийг нэвтрүүлэх, гэмт хэргийн шинжилгээг үнэн зөв дүгнэлт гаргах нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээнүүд,

БХС-ын төсвийн багцын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд Зэвсэгт хүчний техникийг шинэчлэн өөрчлөх, материаллаг баазыг өргөтгөх арга хэмжээнүүд тус тус тусгагдсан байна.

1.2 Салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрүүдийг зохицуулсан нэгдсэн бодлого алга байна

Сангийн сайдын 2008 оны 53 дугаар тушаалаар баталсан “Улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, гүйцэтгэл гаргах журам”-ын дагуу байгууллагуудын боловсруулсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төслийг хүлээн авч хянаж, нэгтгэн ХЗДХЯ 35.4 тэрбум төгрөгийн 120 төсөл арга хэмжээг, БХЯ 26.5 тэрбум төгрөгийн 50 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр Сангийн яаманд тус тус хүргүүлсэн байна. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэлийг графикаар харуулав.



Энэ хөрөнгө оруулалтын төсөлд зөвхөн улсын төсвийн болон МУХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг төлөвлөсөн бөгөөд зээл, тусламж, өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөөгүй байна. Энэ нь хөрөнгийн эх үүсвэрүүдийг уялдуулсан нэгдсэн бодлого, төлөвлөгөө байхгүйг харуулж байна. /Хавсралт 1/


Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хууль болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулиар батлагдсан батлан хамгаалах болон хуулийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал:

ТЕЗ, нэр	байгууллагын	2008 оны хөрөнгө оруулалт		Үүнээс:			
		объектын тоо	үнийн дүн	Улсын төсөв		МУХС	
				объектын тоо	үнийн дүн	объектын тоо	үнийн дүн
1 Батлан сайд	хамгаалахын	36	25 270.4	30	5 410.4	6	19 860.0
2 Хууль хэргийн сайд	зүй, дотоод	102	21 117.0	91	12 481.0	11	8 636.0

3	Авлигатай тэмцэх газар	3	1 267.0	2	400.0	1	867.0
4	Улсын прокурорын газар	9	1 516.8	8	1 504.7	1	12.1
5	УДШ-ийн Ерөнхий шүүгч	3	189.9	3	189.9		
6	Шүүхийн ерөнхий зөвлөл	7	2 957.7	7	2 957.7		
Дүн		160	52 318.8	141	22 943.7	19	29 375.1

Батлан хамгаалах болон хуулийн байгууллагын 2008 оны хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн 56 хувийг Монгол Улсыг хөгжүүлэх сангаас, 44 хувийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

2008 онд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын 2818,5 сая төгрөгийг их засварт, 25006,8 сая төгрөгийг машин техник, тоног төхөөрөмжид, 19751,7 сая төгрөгийг шинээр барих барилга байгууламжид зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд зардлын бүтцийг графикаар харуулбал:



1.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зарим барилга байгууламжийн зураг, төсвийг тухайн онд нь хийж эхлэхээр тусгасан байна

Батлан хамгаалах болон хуулийн байгууллагууд 2008 онд улсын төсөв, МУХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын барилга байгууламжийг төлөвлөхдөө Сангийн сайдын 2006 оны 85 дугаар тушаалаар баталсан хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах зааврыг мөрдлөг болгосон бөгөөд зааврын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчид зураг, төсөв нь бэлэн болсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөгөөний төсөлд тусгасан байна.

Гэвч архивын нэгдсэн барилга 2010 онд ашиглалтад орох учир 2008 онд зураг төсөв, барилгын суурийн ажилд зориулж 300.0 сая төгрөгийг, ГИХАЭГ-ын албан конторын барилгын зураг төсвийг хийлгэж эхлүүлэхээр 600.0 сая төгрөгийг төлөвлөгөөнд тусгажээ.

Хөрөнгө оруулалтын хэтийн бодлого, төлөвлөгөө боловсруулж мөрдсөн болон хөрөнгө оруулалтын эрэлт, хэрэгцээ, шаардлагыг бодитой тогтоосон эсэх асуудлаар БХЯ, ХЗДХЯ, ЦЕГ, УДШ, ШШГЕГ, УЕПГ-ын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан удирдах

болон гүйцэтгэх ажилтнуудаас авсан нийт 72 асуулгын дүнг нэгтгэхэд 26.4 хувь нь сөрөг, 73.6 хувь нь эерэг хариулт өгчээ.

Сөрөг хариултын дийлэнхийн үндэслэлийг жагсаавал:

- Засгийн газраас өргөн мэдүүлсэн ХО-ын төлөвлөгөөнд ТЕЗ-дын санал бүрэн тусаагүй
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах, нэгтгэхдээ холбогдох байгууллага, албан тушаалтны саналыг тусгах талаар эрх зүйн орчин хангалттай биш байна.
- Төсөвт өртгийг үндэслэл муутай тооцсоноос гүйцэтгэлийн явцад нэмэгдэл хөрөнгө шаардагдаж, төсөвт хүндрэл учруулсан
- Салбарын хөрөнгө оруулалтын арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрүүдийг зохицуулсан бодлого боловсруулаагүй
- Салбарын яам, газар тухайн салбарын болон бүс нутгийн хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулаагүй
- Тухайн санхүүгийн жилд зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах тэргүүлэх ач холбогдол бүхий төслийн жагсаалтыг тусгайлан гаргаж, хөрөнгө оруулалтын төсөлтэй хамт холбогдох газар албан ёсоор хүргүүлээгүй
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвт өртгийг бодитой үндэслэлтэй тооцсон эсэхийг хянадаг үр нөлөөтэй тогтолцоо байхгүй
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол, өөрчлөлт хийх саналыг салбар, орон нутгаас гаргаагүй
- Хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөнд орсон тодотгол, зохицуулалт нь хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвт өртгийг бодит байдлаас зөрүүтэй тооцоолсон
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрүүдийг тодорхойлоогүй

Эерэг хариултын олонхийн үндэслэлийг жагсаавал:

- Зураг төсөв нь бэлэн бус, хэрэгцээ хангаагүй төсөл арга хэмжээнд хөрөнгө зарцуулахаар төлөвлөөгүй
- ТЕЗ төсвийн хүрээний мэдэгдлийн дагуу төсвийн төслийг боловсруулсан
- Сангийн яам хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах, нэгтгэхдээ төрөөс баримталж байгаа Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хэтийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулсан
- Төсвийн төслийг хуулийн хугацаанд Засгийн газар, УИХ-д өргөн мэдүүлсэн
- ТЕЗ-дын боловсруулсан хөрөнгө оруулалтын төслийн дийлэнх хувь нь Төсвийн тухай хуульд орж батлагдсан
- Хөрөнгө оруулалтын стратеги төлөвлөгөөг боловсруулах, нэгтгэх, мэдээлэх, тайлагнах, хянах хууль эрхийн акт хангалттай

Бүлэг 2

Гүйцэтгэгчийг шалгаруулахдаа хууль зөрчиж байна

2.1 Зарим байгууллага худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөө нийтэд мэдээлээгүй байна

Батлан хамгаалах болон хуулийн байгууллагууд 2008 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн жилд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган Сангийн яамны e-procurement.mn вэб сайтад байршуулсан байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 48.5-д “захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн эхний сард хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэж заасныг зөрчиж БХЯ, УЕПГ, АТГ, УДШ худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэвлэлд нийтлүүлж нийтэд зарлан мэдээлээгүй байна.


ГИХАЭГ 2008 онд худалдан авах төлөвлөгөө боловсруулаагүй нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 48.1-д “захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан боловсруулж улсын төсөв батлагдсанаас хойш 30 хоногийн дотор харъяалах ТЕЗ-чид хүргүүлнэ” гэж заасныг зөрчжээ.

Батлан хамгаалах болон хуулийн байгууллагууд хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох тендерийн урилгын ихэнхийг Зууны мэдээ, Нийгмийн толь, Зууны шуудан сонинд нийтлүүлжээ. Өнөөдөр сонинд хэвлүүлсэн 1-2 урилгыг эс тооцвол хамгийн олон уншигчтай Өнөөдөр, Өдрийн сонин зэрэг сонинуудад тендерийн урилгыг хэвлүүлээгүй байна.

2.2 Төрийн нууцын тухай хуулийн дагуу худалдан авах үйл ажиллагаанд шууд гэрээ байгуулсан байна

Батлан хамгаалах болон хуулийн байгууллагууд 2008 оны худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийн 21.0 хувийг нээлттэй тендерээр, 25.0 хувийг харьцуулалтын аргаар, 54.0 хувийг шууд гэрээ байгуулах замаар сонгосон байна. Үүнийг график болон хавсралт маягт №3 -аар үзүүлэв.

Батлан хамгаалах, хуулийн байгууллагуудын бараа, ажил худалдан авах ажиллагаанд шууд гэрээ байгуулах аргыг түлхүү хэрэглэсэн нь сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангах, ил тод байх, шударгаар өрсөлдөх зарчмыг алдагдуулж байна. Гэхдээ энэ нь батлан хамгаалах, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын барилга байгууламж барих бүс, зарим тусгай тоног төхөөрөмжөөр хангах ажиллагаа хуулийн дагуу төрийн нууцад хамаарагддаг, гадаадын тусламжийн хөрөнгөөр машин, тоног төхөөрөмж нийлүүлсэнтэй холбоотой юм.



ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар ГИХАЭГ-ын албан кноторын барилга болон ЦЕГ, ХХЕГ-т автомашин нийлүүлэх арга хэмжээг багцлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулсан ба бусад хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ бүрээр агентлаг, байгууллагуудын Төсвийн ерөнхий менежерүүд Үнэлгээний хороо байгуулжээ.

Харин БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2008 оны 11, 29 дүгээр тушаалуудаар тухайн онд хэрэгжих барилга байгууламж, их засварын ажлын болон худалдан авах тоног төхөрөөмжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог тус тусад нь байгуулжээ. Мөн хэрэгжих объект болон худалдан авалт бүрээр гүйцэтгэгчийг шалгаруулах Үнэлгээний хороо байгуулахын оронд үнэлгээний ажлын хэсгийн бүрэлдэхүүн гэж байгуулсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.2-т “Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх ...” гэж заасныг зөрчсөн байна.

ШШГЕГ 2008 онд хорих ангийн барилга, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийн гүйцэтгэгчийг сонгохдоо Төрийн нууцын тухай хуулийн 3.2-т “үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс зарим барилга, байгууламж \цаашид “объект” гэх\, төрийн эрх барих байгууллагаас хэрэгжүүлж байгаа тодорхой үйл ажиллагааг төрийн нууцад хамааруулж болно”, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 57-д “улсын онц чухал болон тусгай объект, үйл ажиллагааг халхлах ...” гэсэн заалтад хамрагдаж маш нууц зэрэглэлд багтдаг учир тодорхой шийдвэр авахаар Сангийн яаманд хандсан байна.

Сангийн яам хорих ангийн объект, тусгай зориулалтын тоног төхөөрөмж нь нууцын тухай хуулиудад хамаарч байгаа тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.3 дахь хэсгийг үндэслэн тендер зарлалгүйгээр хорих ангийн дотоод нөөц бололцоог ашиглан хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албадтай шууд гэрээ байгуулах боломжтой гэсний дагуу шилжиж ирсэн болон шинээр барих барилга, объект, их засварын ажлыг харьяа хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албадаар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна.

Хил хамгаалах заставуудын барилга угсралтын ажил нууцын зэрэглэлд хамаарах учраас Хилийн барилгын цэргийн 0119 дүгээр ангитай барилга байгууламж барих, их засварын ажил гүйцэтгэх 8 гэрээ байгуулжээ. Улсын хил хамгаалалтад ашиглах газар уснаа явагч, ус, цаснаа явагч хөвөгч, аврах хэрэгсэл, дуран харааны хэрэгсэл, 3 дугуйт мотоцикл худалдан авах 892.9 сая төгрөгийн өртөгтэй тендерт санал ирээгүй бөгөөд ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30.1.1-д “шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй” гэсэн заалтыг үндэслэн Сангийн яаманд шууд гэрээ байгуулах санал явуулжээ.

Сангийн яам ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34.1.1 дэх заалтыг үндэслэн шууд худалдан авах гэрээ байгуулахыг зөвшөөрсний дагуу гэрээ байгуулжээ. ГИХАЭГ-т хэрэгжүүлж байгаа 350,0 сая төгрөгийн өртөг бүхий боомтуудыг “Иргэний бүртгэл, паспорт хяналтын нэгдсэн сүлжээ”-нд холбох төслийн ажил Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1.17 дугаар заалт, Төрийн нууцын тухай хуулийн дагуу “маш нууц” зэрэглэлд тооцогдох тул ТБОНӨХБАҮХАТ хуулиар зохицуулагдахгүй шууд гэрээгээр хийж болно гэсэн Сангийн яамны зөвшөөрлийн дагуу гүйцэтгэгчийг сонгохдоо эхний шатны ажлын гүйцэтгэгчийг улируулан шууд гэрээ байгуулсан байна.

ГИХАЭГ-т зохион байгуулагдсан барилгын тендерийн баримт бичиг болон техникийн тодорхойлолтыг хэрхэн бэлтгэсэн нь тодорхой бус, худалдан авах ажиллагаа явуулсан талаар хавтаст материал алга байна.

Дорнод аймгийн 327 дугаар цэргийн ангид 12 айлын орон сууц барихаар 285.0 сая төгрөг төлөвлөсөн боловч Батлан хамгаалахын сайдын 2008 оны 393 дугаар тушаалаар Дорнод аймгийн Хэрлэн сумд барьж ашиглалтад оруулсан 60 айлын орон сууцнаас 559,2 квм талбай бүхий 12 орон сууцыг шууд гэрээ байгуулах аргаар худалдан авсан нь нээлттэй тендер зарлаж гүйцэтгэгчийг сонгох хуулийн заалтыг зөрчсөн байна.

2008 онд Улсын ерөнхий прокурорын газар 118.0 сая төгрөгөөр автомашин худалдан авахаар нээлттэй тендер 2 удаа зарласан боловч санал ирээгүй шалтгаанаар хөрөнгийг харьяа газрууддаа хуваарилан харьцуулалтын аргаар микро автобус 1 ширхэгийг 50,0 сая төгрөгөөр, Сүхбаатар, Говьсүмбэр, Говь-Алтай аймгуудын прокурорын газар, Хөтөл тосгоны сум дундын прокурорын газар, Налайх, Сонгинохайрхан дүүргүүдийн прокурорын газарт 6,0-16,0 сая төгрөгийн үнэтэй 6 суудлын автомашин худалдан авсан байна.

Хорих ангиудын аюулгүй байдал, шуурхай байдлыг хангах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж бэлтгэх 350.0 сая төгрөгөөр зайлшгүй шаардлагатай автомашин авахаар Төрийн өмчийн хороонд хандсаны дагуу Төрийн өмчийн хороо зөвшөөрөл өгсөн байна. ШШГЕГ машин авах хөрөнгийг харьяа хорих анги, байгууллагуудад хуваарилан тэдгээр нь харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгож, 5.0-21.8 сая төгрөгийн үнэтэй 32 автомашин худалдан авчээ.

Эдгээр үйл ажиллагаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.5-д “энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэж заасныг зөрчжээ.

ГИХАЭГ Үнэлгээний хороо байгуулж, нээлттэй тендер зарлалгүй 100,0 сая төгрөгийн эд хогшил, автомашин худалдан авах ажиллагааг шууд худалдан авалтаар хэрэгжүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.2-т “энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 17.1-д “нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21-р зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана” гэж заасныг зөрчсөн байна.

ЦЕГ шинээр барих барилга байгууламжийн гүйцэтгэгчийг сонгох нээлттэй болон хязгаарлагдмал тендер 1-2 аж ахуйн нэгж саналаа ирүүлсэн бөгөөд ирүүлсэн санал хэт өндөр үнэтэй байсан учир ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30.1.1-д “шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй”, 30.1.1-д “шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн” гэж заасны дагуу хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулжээ. Гэвч шалгаруулалтад дээрх нөхцөл байдал дахин үүссэн учир ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30.4.3-т “энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны

дагуу явуулсан тендер шалгаруулалтын онцгой нөхцөл байдал үүсвэл шууд гэрээ байгуулах” гэж заасны дагуу гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулжээ.

Сүхбаатар дүүргийн Цагдаагийн хэлтсийн Дамбадаржаа дахь Цагдаагийн тасгийн барилга 2008 оны төлөвлөгөөнд 350.0 сая төгрөгийн өртөгтэйгээр тусгагдсан бөгөөд уг барилгын гүйцэтгэгчийг сонгох нээлттэй тендерийг 2 удаа зохион байгуулсан боловч тендерт ямар ч байгууллага оролцоогүй байна. Тус барилгыг барих газрын хөрс нь цэвдэгтэй, тодорхой даралтын дор суулт үүсэх шинж чанартай, геологийн төвөгтэй нөхцөлд байршина гэсэн дүгнэлт гарсан, дэд бүтцийн асуудлыг шийдэхэд нэмэлт хөрөнгө шаардлагатай байсан учир уг төсөвт багтаан барилга худалдаж авах саналыг Сангийн ямаар дамжуулан Засгийн газарт тавьсан байна.

Засгийн газар уг асуудлыг хэлэлцээд батлагдсан төсөвтөө багтаан холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдаж авахыг ХЗДХС-д протоколоор зөвшөөрсөн байна. Улмаар ТӨХ-ны шийдвэр гаргуулан иргэн Б.Жаргалсайханаас 350.0 сая төгрөгөөр 4 давхар барилгыг худалдан авсан байна.

БХЯ Цэргийн нэгдсэн эмнэлэгт нийлүүлэх компьютер томографын аппаратыг нийлүүлэх 120,0 сая төгрөгийн үнэлгээтэй ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Төрийн нууцын тухай хуулийн 5.2 дахь заалтад хамааруулан харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгожээ.

БХЯ-ны Үнэлгээний хороо нь төрийн нууцад хамаарч байгаа гэсэн үндэслэлээр шууд гэрээ байгуулахдаа гэрээний нэмэлт зүйлийг товч хийж, гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ, нийлүүлэх тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл, тодорхойлолтыг дутуу тусгасан байна. Тухайлбал, “Камаз” маркын автомашин нийлүүлэх гэрээний тусгай нөхцөлд зөвхөн “Камаз-53212” гэж зааж, тухайн машины өнгийг зааж өгөөгүйгээс өнгө тохирохгүй автомашин нийлүүлжээ. Уг автомашины өнгийг солиулахаар санал тавиад байна.

2.3 Худалдан авах ажиллагааны тайланд тайлбар, нотолгоог дутуу тусгаж байна

Батлан хамгаалах болон хуулийн байгууллагууд ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49.1-д “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны тендер бүрээр хуульд заасны дагуу бүрдүүлж хавтаслан архивт хадгалсан байна.

Архивын баримтыг шалгахад аудитад хамрагдсан бүх байгууллага тендерийн урилга нийтлүүлсэн сонинг бүтнээр нь биш урилгыг хайчилбар хийж хадгалсан бөгөөд хэдний өдрийн ямар нэртэй сонин гэдгийг тодорхойлоход төвөгтэй байлаа.

Захиалагчид худалдан авах ажиллагааны тайланг тогтоосон хугацаанд нь ТЕЗ, Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд Сангийн яам ТЕЗ-ийн худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэж үнэлэлт, дүгнэлт өгчээ. Сангийн яамнаас өгсөн үнэлгээг ТЕЗ бүрээр сүүлийн 3 жилийн байдлаар хүснэгтээр харуулбал:

ТЕЗ-ийн нэр		Авсан оноо		
		2006	2007	2008
1	ШЕЗ	36	0	85
2	УДШ	35	66	92
3	АТГ	-	30	62
4	БХС	71	71	71
5	ХЗДХС	39	68	49
6	УЕПГ	94	70	80

Хүснэгтээс үзэхэд батлан хамгаалах болон хуулийн байгууллагуудын худалдан авах ажиллагаа ерөнхийдөө тогтмолжиж, “хангалттай” гэсэн үнэлгээнд хүрчээ. Харин ХЗДХС-ын 2008 оны худалдан авах ажиллагаа “хангалтгүй” үнэлгээ авсан ба энэ нь гүйцэтгэгчийг сонгосон тайлбар нотолгоог тайландаа дутуу тусгасантай холбоотой байна.

Ховд аймгийн шүүх орон сууц худалдан авах ажиллагаанд шууд гэрээ байгуулсан, Өвөрхангай аймгийн Сант сумын цагдаагийн кабоны байрны төсөвт өртөг 46,0 сая төгрөгөөр батлагдсан боловч, төсөвт өртгийг нэмэгдүүлж 72,0 сая төгрөгөөр тендерийг зарласан, Орхон аймгийн прокурорын газраас Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр орон сууц, автомашин худалдаж авахдаа үнэлгээний хороо байгуулаагүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Говь сүмбэр аймгийн Шүүхийн орон сууц, тоног төхөөрөмжийг шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн, Баянтал суманд цагдаагийн кабон барих, 2 айлын орон сууц засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа үнэлгээний хороо байгуулаагүй, тендерийн тодорхойлолт, нөхцлийг дутуу тусгасан байна.

Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан уу гэсэн асуудлаар Батлан хамгаалах болон хуулийн байгууллагуудаас авсан нийт 145 асуулгын дүнг нэгтгэхэд 21,9 хувь нь сөрөг, 78,1 хувь нь эерэг хариулт өгчээ.

Сөрөг хариултын дийлэнхийн үндэслэлийг жагсаавал:

- Захиалагч ХАА-ны төлөвлөгөөг 1 дүгээр сард багтаан өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр зарлан мэдээлээгүй
- 1,0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил, тендерийн урилгыг олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг хэл дээр гардаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлээгүй
- 100,0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээний тендерийн урилгыг олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг хэл дээр гардаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлээгүй
- Үнэлгээний хороонд ТББ-ын төлөөлөл оролцоогүй
- Тендерт оролцогчтой санал солилцсоны дараа захиалагч жишиг техникийн тодорхойлолт гаргаагүй
- ХАА-г нэгтгэн дүгнэж улсын хэмжээний мэдээллийн сан бүрдүүлээгүй
- Тендерт оролцох эрхээ хасуулсан этгээдийн бүртгэл хөтөлж, хяналт тавьж, нийтэд мэдээлээгүй
- Худалдан авах ажиллагааны талаар тендерт оролцогчдод сургалт зохион байгуулаагүй

Эерэг хариултын олонхийн үндэслэлийг жагсаавал:


- Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлсэн
- Үнэлгээний хороог ХАА тус бүрт байгуулсан
- Тендерт оролцогчтой гэр бүлийн болон төрөл, садны холбоотой гишүүн байгаагүй
- Тендерийг үнэлэхдээ үнийг шалгуур үзүүлэлт болгон авч үзсэн
- Тендер нь ТББ-т заасан ерөнхий нөхцлийг хангасан

Бүлэг 3

Зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг хуурамчаар гаргаж санхүүжүүлжээ

3.1 2008 онд Батлан хамгаалах болон хууль, хүчний байгууллагын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 72.0 хувийг улсын төсвийн болон МУХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлжээ


Батлан хамгаалах болон хууль, хүчний байгууллагуудын 2008 оны хөрөнгө оруулалтыг хөрөнгийн эх үүсвэрээр харуулбал:



2008 оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн 40 хувийг МУХС-ийн хөрөнгөөр, 32 хувийг улсын төсвийн хөрөнгөөр, 19 хувийг гадаадын тусламжийн хөрөнгөөр, 5 хувийг өөрийн хөрөнгөөр, 4 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө, урсгал зардал, бусад эх үүсвэрээр тус тус хэрэгжүүлсэн байна.

Төлөвлөгөөнд тусгагдаагүй орон нутгийн төсөв, гадаадын тусламж, өөрийн хөрөнгө, бусад ТЕЗ-ийн төсвийн багцаас санхүүжүүлсэн хөрөнгийн дүнгээс шалтгаалан гүйцэтгэлийн дүн өссөн байна. Тухайлбал, БХЯ өөрийн хөрөнгөөр 687.5 сая, гадаадын тусламжийн хөрөнгөөр 9364.6 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмж авсан, ХЗДХС гадаадын тусламжийн хөрөнгөөр 3767.7 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийн, өөрийн хөрөнгөөр 2564.6 сая төгрөгийн барилга байгууламжийн санхүүжилт тус тус хийсэн нь гүйцэтгэл төлөвлөгөөнөөс давахад нөлөөлжээ.

2008 оны хөрөнгө оруулалтын бүтцийг графикаар харуулбал:



(батлан хамгаалах болон хуулийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын судалгааг хавсралт хүснэгтээс үзнэ үү.)

Нийт хөрөнгө оруулалтын 65 хувийг машин, тоног төхөөрөмж худалдан авахад, 30 хувийг шинээр баригдах болон шилжих объектыг санхүүжүүлэхэд, 5 хувийг их засвар болон тавилга эд хогшил худалдан авахад тус тус зарцуулсан байна.

2008 онд батлан хамгаалах салбарт 2 нисдэг тэрэг, цагдаагийн байгууллагад 129 автомашин авч автомашин, техник хэрэгслийн шинэчлэлд ихээхэн хөрөнгө зарцуулсан нь нийт хөрөнгө оруулалтад эзлэх машин, тоног төхөөрөмжийн санхүүжилтийн дүн өсөхөд нөлөөлсөн байна.

Түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хоригдогсдын байрыг шинэчилсэн, хил хамгаалах байгууллага хилийн отрядтай холбогдох харилцаа холбоонд шинэ технологи нэвтрүүлсэн, шүүхийн шинжилгээний байгууллага хэргийн ул мөрийг шинжлэх шинэ тоног төхөөрөмж, шинэ байрыг ашиглаж эхэлсэн, ГИХАЭГ, АЕГ ажлын шинэ байртай болох эхлэл тавигдсан зэрэг нь онцлог байв.

3.2 Улсын комисс хүлээн аваагүй барилгыг ашиглаж байна

Нийслэлийн прокурорын газрын конторын барилгын гүйцэтгэгчээр “Их Онги” ХХК шалгарч барилгыг 2008 оны 12 дугаар сарын 15-нд ашиглалтад оруулахаар гэрээ байгуулж гүйцэтгэсэн боловч барилгыг хүлээн авах Улсын комисс барилгын холбооны шугамын холболт хийгдээгүй, барилгын цонхнууд цан цохисон, барилгын хана холцорсон зэрэг шалтгаанаар хүлээн аваагүй байна. Гэвч барилгыг захиалагч байгууллага ашиглаж эхэлжээ.

Ховд аймгийн прокурорын газрын 2 айлын орон сууцны барилгын тендерт “Алтайн буйлааст” ХХК шалгарч барилгын төсвийг 35.2 сая төгрөгөөр гүйцэтгэхээр санал ирүүлсэн боловч гэрээ хийх явцад тодорхой шалтгаангүйгээр барилгын төсвийг 36,1 сая төгрөг болгон нэмэгдүүлж санхүүжүүлжээ.

Батлан хамгаалах болон хуулийн байгууллагуудын хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгасан байдлыг тулган шалгахад доорх зөрчлүүд илрэв. Үүнд:

Хил хамгаалах ерөнхий газарт хил хамгаалалтын харилцаа холбоог шинэчлэх, боловсронгуй болгох зорилгоор АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр нийлүүлсэн 2847,8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр нийлүүлсэн 390,9 сая төгрөгийн цэргийн ачаа тээврийн 7 ширхэг автомашин, Дорнод аймгийн Сүмбэрийн боомтод хилийн байгууламж барих 374,0 сая төгрөгийн барилгын материал, Шадар сайдын төсвийн багцаас олгосон 36,7 сая төгрөгийн зураг төсвийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Улсын ерөнхий прокурорын газрын конторын барилгын их засварт 196,5 сая төгрөг, Сонгинохайрхан дүүргийн прокурорын конторын барилгын их засварт 50,0 сая төгрөг, Говьсүмбэр, Сүхбаатар, Говь-Алтай, Ховд аймгуудын прокурорын газрын конторын барилга, Хөтөл, Зүүнхараа, Хархорины прокурорын газрын конторын барилгын их засварт 46,0 сая төгрөг, Баянгол дүүргийн прокурорын газрын цахилгааны засварт 2,0 сая төгрөг, нийтдээ 294.5 сая төгрөг зарцуулжээ. Гэвч дээрх их засварууд нь барилгын эдэлгээг уртасгаагүй гэдэг шалтгаанаар хөрөнгийг нэмэгдүүлж данс бүртгэлд тусгаагүй байна.

БХЯ өөрийн хөрөнгөөр 687.5 сая төгрөг, гадаадын зээл тусламжаар 9364.6 сая төгрөгийн техник тоног төхөөрөмж, бараа материалыг хүлээн авсан боловч зээл тусламжаар ирсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Хил хамгаалах ерөнхий газрын худалдан авсан Sinotrik маркийн ачааны автомашины тэвш нь нимгэн төмрөөр хийгдсэнээс техникийн тодорхойлолтод заасан 20 тн ачаа ачих боломжгүй бөгөөд кузов хугарч, урагдсан байна.



Төрийн өмчийн хорооны шийдвэрийн дагуу ХЗДХЯ “Соната НФ-6” маркийн суудлын автомашиныг дэд сайдын албан хэрэгцээнд худалдан авахаар “Монгол Хьюндэй Киа” ХХК-тай шууд гэрээ байгуулж, машины үнэ 25.0 сая төгрөгийг Төрийн өмчийн хороо уг компанид шилжүүлжээ. Машин худалдан авсан хөрөнгө нь төрийн байгууллагуудын төвлөрүүлсэн автомашинаас илүүдэлтэй автомашиныг дуудлага худалдаагаар борлуулсны орлого бөгөөд энэ хөрөнгийг хэрхэн зарцуулан талаар зохих шийдвэр гараагүй байхад ТӨХ дур мэдэн зарцуулсан байна.

ШШГЕГ 2008 онд ялтныг нийгэмшүүлэх, ажлын байраар хангах, хоригдогсдын байрыг шинэчилж, хорих анги болон цагдан хорих байрны харуул хамгаалалтыг сайжруулах, орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 4646.4 сая төгрөгийн барилга байгууламж, их засварын ажил гүйцэтгэсний 46.2 хувь буюу 2147.0 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр, 53.8 хувь буюу 2499.4 сая төгрөгийг өөрийн орлогоор санхүүжүүлсэн байна.

Засгийн газрын 2007 оны 188 дугаар тогтоолоор дотоод нөөц бололцоогоо ашиглан хорих ангиудыг хамгаалалтын бетонон хашаатай болгох, үйлдвэрлэлийг сэргээх, ялтанд мэргэжлийн дадлага олгож улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барих барилга байгууламж, их засварын ажил хийлгэх замаар ялтны ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг ХЗДЗСайд, ШШГЕГ-ын дарга нарт үүрэг болгосны дагуу 2008 онд баригдах барилга байгууламж, их засварын ажлыг хоригдлуудаар гүйцэтгүүлж, 224 хоригдлын 8 байр, 80 ортой сүрьеэгийн эмнэлэг, хамгаалалтын хашаа, ШШГЕГ-ын конторын барилгын өргөтгөл зэрэг нийтдээ 24 объектийг тайлант хугацаанд барьж ашиглалтад оруулсан байна.

Хорих ангиудын аюулгүй, шуурхай байдлыг хангах зорилгоор улсын төсвийн болон өөрийн 396.0 сая төгрөгийн хөрөнгөөр зайлшгүй шаардлагатай 32 автомашиныг худалдан авах зөвшөөрлийг хуулийн дагуу ТӨХ-ноос авсан боловч худалдан авахдаа харьцуулалтын аргыг хэрэглэжээ.



Шинээр барьсан хоригдлын байр

ШШГЕГ 9584.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга байгууламж, их засварын ажлыг 3162.2 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна. Тухайлбал, 641.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 224 хоригдлын байрыг 210.0 сая төгрөгөөр, 268.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сүрьеэгийн эмнэлгийн барилгыг 106.4 сая төгрөгөөр тус тус барьжээ.

ШШГЕГ барилга байгууламжийн төсөвт өртгийг дунджаар 50,7 хувиар хэмнэж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлсэн байна. Энэ хэмнэлт нь хөдөлмөрийн зардлыг 100 хувь хэмнэж, хайрга, блок, тоосго, вакум цонх зэрэг барилгын үндсэн материалуудыг дотооддоо үйлдвэрлэснээс шалтгаалжээ.

3.3 Улсын архивын нэгдсэн барилгын ажлыг эхлээгүй байна

Улсын архивын нэгдсэн барилгын суурийн ажлыг хийхээр 300.0 сая төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгасан боловч зураг, төсөв нь оройтож бэлэн болсноос уг ажлыг гүйцэтгээгүй байна.

2008 онд хөрөнгө оруулалтаар шинээр эхэлж, 2009 онд шилжин баригдаж байгаа ЦЕГ-ын тусгай хэлтсийн барилга, Цагдаагийн нэгдсэн архивын барилга, Баянзүрх дүүргийн замын цагдаагийн тасгийн барилга, 200 автомашины гаражийн барилга, Өвөрхангай аймгийн Хархорин сумын цагдаагийн хэлтсийн барилгуудын төсөв нь 2005 онд хийсэн төсвөөр төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд энэ төсвийг барилгын материал, шатахуун, хөдөлмөрийн үнийн өсөлтөөс хамааруулж нэмэгдүүлэх шаардлага гарсан байна. ЦЕГ-ын зарим барилгын явцыг зургаар үзүүлбэл:



Цагдаагийн тусгай хэлтсийн барилга



Цагдаагийн нэгдсэн архивын барилга

2008 онд ЦЕГ-ын харъяа 20 байгууллагад 303.3 сая төгрөгийн их засварын ажил хийгдсэнээс Цагдаагийн соёл олон нийтийн төвийн зааланд хадгаламж зээлийн хоршоодын холбогдолтой хураагдсан эд материал битүүлэгдэн хадгалагдаж байснаас заал чөлөөлөх хугацаа хойшлогдсон, цагдаагийн “Цагаан шонхор” УУГ-ын дээвэр, засварын ажлын санхүүжилт оройтсон, өвлийн улиралд технологийн горим зөрчихгүй байх, хямд материал авах зэрэг шалтгаанаар засварын ажил бүрэн хийгдээгүй байхад хийсэн гэж 65.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарган санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагад олгожээ.

ЦЕГ-ын конторын барилгад 30.0 сая төгрөгөөр их засвар хийсэн бөгөөд 10 өрөө тасалгаа, ариун цэврийн өрөөг зассан нь барилгын эдэлгээг уртасгахад нөлөөлөх их засвар биш байна.

2008 онд ГИХАЭГ-т улсын төсвийн хөрөнгөөр 1048.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ хэрэгжсэн бөгөөд 600.0 сая төгрөг нь тус байгууллагын албан конторын барилгад, 350,0 сая төгрөг нь боомтуудыг “Иргэний бүртгэл, паспорт хяналтын нэгдсэн сүлжээ”-нд холбох төслийн ажилд, 100,0 сая төгрөг нь эд хогшил, автомашин худалдан авахад зарцуулагдсан байна.

ГИХАЭГ эд хогшил, машиныг шууд худалдан авсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчсөн байна.

ШШҮХ-ийн албан контор, лабораторын нэгдсэн барилгыг 2006-2008 онд барьж дуусган нийт 1238,9 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд төсөвт өртгөөс дутуу

340,0 сая төгрөгийг 2009 оны төсвийн төлөвлөгөөнд тусгаагүй байна. Барилгыг улсын комисс 2008 оны 12 дугаар сарын 7-нд хүлээн авч, тус байгууллага шинэ байрандаа үйл ажиллагаагаа явуулж байгаа ба барилгын ажлыг гүйцэтгэгч “Суурь” ХХК нь барилгын төсөвт өртгийн зөрүүг өөрийн хөрөнгөөс гаргажээ.

ШШҮХ-д Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлж, чадавхи сайжруулах” төслийн хүрээнд буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 9,9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эд хогшил нийлүүлснийг хүлээн авч, данс бүртгэлдээ тусгасан байна.

ТТАХНЭ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 50,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, Эрүүл мэндийн яамнаас 9,7 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж хандивласныг данс бүртгэлдээ тусган бүртгэсэн байна.

БХЯ улсын төсвийн хөрөнгөөр Орхон аймаг дахь 186 дугаар ангийн цэргийн албан хаагчдын 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 50 айлын орон сууцыг барихыг өөрчлөн 80,0 сая төгрөгийг тухайн ангийн штабын барилгыг орон сууц болгон өөрчлөхөд, 120,0 сая төгрөгийг Дархан Уул аймаг дахь 330-р ангид полигон барихад зарцуулсан нь Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийг төлөвлөх, гүйцэтгэлийг хянах, санхүүжүүлэх, хяналт тавих, ажлын гүйцэтгэл гаргах журмын 1.5-д “Улсын болон орон нутгийн төсөв, Монгол улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг хооронд нь шилжүүлэн санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

2008 онд АТГ 1659.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын арга хэмжээ хэрэгжүүлснээс байгууллагын үйл ажиллагаанд зориулж 362.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан бөгөөд гүйцэтгэх ажлын зардлаас 357.4 сая төгрөгийн, МУХС-гийн хөрөнгөөс 867.0 сая төгрөгийн, нийт 1224.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг гүйцэтгэх ажлын хэрэгцээнд зарцуулсан нь тус газарт хийгдсэн хөрөнгө оруулалтын 73.8 хувийг эзэлж байна.

Батлан хамгаалах болон хуулийн байгууллагуудаас ирүүлсэн хөрөнгө оруулалтын судалгааг шалгахад БХЯ тусламжийн 11106.7 сая төгрөгийн хөрөнгө, Хил хамгаалах ерөнхий газарт хил хамгаалалтын харилцаа холбоог шинэчлэх, боловсронгуй болгох зорилгоор АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр нийлүүлсэн 2847,8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр нийлүүлсэн 390,9 сая төгрөгийн цэргийн ачаа тээврийн 7 ширхэг автомашин, Дорнод аймгийн Сүмбэрийн боомтод хилийн байгууламж барих 374,0 сая төгрөгийн барилгын материал, ХЗДХЯ-нд хэрэгжиж байгаа ХБНГУ-ын тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйг боловсронгуй болгох төсөлд авсан 70.2 сая төгрөгийн үнэтэй автомашин, ШШҮТ, ГИХАЭГ, ТТАХНЭ-д тусламжаар авсан 69.9 сая төгрөгийн хөрөнгийг судалгаанд тусгаагүй байна.

Шадар сайдын төсвийн багцаас ХЗДХЯ-ны харьяа байгууллагуудад олгосон 224.2 сая төгрөгийн зураг төсөв, ХЗДХЯ ТӨХ-ны хөрөнгөөр худалдан авсан 25.0 сая төгрөгийн үнэтэй суудлын автомашиныг судалгаанд хамруулаагүй байна.

БХЯ “Транс сэргэлт” ХХК-тай 2008 оны 11-р сарын 30-ны дотор 46,9 сая төгрөгийн сум нийлүүлэх гэрээ байгуулж, сумны үнэ 46,9 сая төгрөгийн санхүүжилтийг 2008 оны 12 дугаар сард тус компанид төлжээ. Гэвч сумыг хүлээн аваагүй, гэрээний үүргийг хангаагүй зөрчил аудитаар илэрсэн байна.

Зэвсэгт хүчний 124 дугаар ангийн 1150,0 сая төгрөгийн төсөвтэй 50 айлын орон сууцны гүйцэтгэлд 1129,4 сая төгрөг буюу 98.2 хувийн санхүүжилтийг олгосон байна. Гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн гүйцэтгэлийг БХЯ-ны Хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн албаны хяналтын инженер 1149,9 сая төгрөгөөр тооцон хянаж баталгаажуулжээ. Барилгын гүйцэтгэлд аудит хийхэд зөвхөн 1 давхрын ажил дутуу хийгдсэн бөгөөд БХЯ-ны удирдлага хуурамч гүйцэтгэл гарган санхүүжилтийг олгожээ.



50 айлын орон сууцны ажлын гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нараас орон нутаг дахь салбар, нэгжүүдэд хуваарилсан хөрөнгө оруулалтын үр дүнд тавих хяналт сул байна. Тухайлбал:

- ✓ Ховд аймгийн Прокурорын газрын 36,1 сая төгрөг орон сууцны барилгыг Улсын комисс хангалттай гэсэн үнэлгээ өгөн хүлээн авсан баримтыг аудитаар шалгахад засал дуусаагүй, гаднах дулааны холболт хийгдээгүй бөгөөд хуурамч гүйцэтгэл гарган санхүүжилтийг бүрэн олгожээ.
- ✓ Говь-Алтай аймгийн Прокурорын газарт улсын төсөөс их засварын зориулалтаар олгосон 13,0 сая төгрөгөөр гаднах зам талбайг тохижуулсан боловч бүртгэлд тусгаагүй байна.
- ✓ Говьсүмбэр аймгийн прокурорын газарт автомашин худалдаж авахад нь зориулж улсын болон орон нутгийн төсвөөс 16,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч худалдан авалттай холбоотой бичиг баримт байхгүй, бүртгэлд жип загварын суудлын автомашиныг 14,0 сая төгрөгөөр тусгасан байна.
- ✓ Дорноговь аймгийн Хатанбулаг сумын 65,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий цагдаагийн кабоны барилга гэрээт хугацаанд ашиглалтад ороогүй байна.
- ✓ Увс аймгийн Бөхмөрөн, Өндөрхангай, Малчин сумд дахь цагдаагийн кабоны 138,0 сая төгрөгийн өртөг бүхий барилгыг данс бүртгэлд тусгаагүй байна.
- ✓ Булган аймгийн Хутаг Өндөр сум дахь цагдаагийн кабоны барилгын санхүүжилтийг 312,0 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн зөрчлийг илрүүлж акт тогтоож, төлүүлжээ.
- ✓ Ховд аймгийн Цагдаагийн хэсгийн 2 барилгыг гүйцэтгэхээр “Турлиах” ХХК-тай гэрээ байгуулан 13,3 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч ашиглалтад ороогүй, Цагдаагийн хэлтэс нь ашиглалтад ороогүй барилгыг данс бүртгэлд авсан байна.
- ✓ Дархан Уул аймгийн Хонгор суманд баригдсан цагдаагийн кабоны барилгыг шалгахад хана, шал цуурсан, гаражийн пар хагарч ус гоожсон, хаалга рамнаасаа салсан байна.

Захиалагч гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, гүйцэтгэлийг үнэлэх, хариуцлага тооцох үйл явц холбогдох хууль тогтоомжийн дагуу үр нөлөөтэй хэрэгжиж байна уу гэсэн асуудлаар БХЯ, ХЗДХЯ, ЦЕГ, УДШ, ШШГЕГ, УЕПГ-аас авсан нийт 97 асуулгын дүнг нэгтгэхэд 33 асуулт буюу 34.0 хувь нь сөрөг, 64 асуулт буюу 66.0 хувь нь эерэг хариулт өгчээ.

Сөрөг хариултын дийлэнхийн үндэслэлийг жагсаавал:

- Захиалагч гүйцэтгэгчийн хороонд байгуулсан гэрээг батлагдсан загварын дагуу байгуулаагүй
- Захиалагч гэрээний хэсэгт тухайн ажлын цар хүрээ, онцлог шинжийг бүрэн тусгаагүй
- Гэрээний заалтанд хариуцлага тооцох функцуудыг тодорхой зааж өгөөгүй
- Тухайн байгууллага нь шууд гэрээ байгуулсан
- Гэрээний гүйцэтгэлийг үнэлэх тусгай шалгуур үзүүлэлт байхгүй
- Гэрээний гүйцэтгэлийн явцад байнга техникийн хяналт тавьж чадаагүй
- Гэрээний гүйцэтгэлийн техникийн хяналт үнэн, зөв явагдаагүй
- Гэрээний гүйцэтгэлийг үнэлсэн талаар дүгнэлт гаргаж, баримтжуулаагүй
- Захиалагч нь гэрээ тус бүрээр гэрээний биелэлтийг гаргаагүй
- Гэрээний биелэлтэд тогтмол үнэлгээ хийдэггүй
- Үнийн өөрчлөлтийг гэрээнд тусгаагүй
- Гэрээнд гэрээний үүргээ биелүүлээгүй тухайн байгууллага болон хувь хүмүүст хариуцлага тооцох функцийг тодорхой зааж өгөөгүй
- Гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд хариуцлага тооцох арга хэмжээ авдаггүй
- Гүйцэтгэгчийн буруугаас болсон хохирлыг тогтоож, хариуцлага тооцсон тохиолдол байхгүй

Эерэг хариултын олонхийн үндэслэлийг жагсаавал:

- Захиалагч нь тендерийн гэрээг байгуулахдаа тухайн байгууллагад бичгээр мэдэгдсэн
- Гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажуулсан
- Гэрээний гүйцэтгэлийг үнэлэх, хянах ажлын хэсгийг томилсон
- Хяналтын ажлыг төв, орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтран хийсэн
- Гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичгийг баримтжуулсан
- Байнгын явцын техникийн хяналт хийсэн тухай тэмдэглэл байсан
- Гүйцэтгэгчийн гаргасан урьдчилгаа төлбөрийн баталгааг захиалагч хянасан
- Явцын техникийн хяналтаар илэрсэн зөрчлийг цаг хугацаанд нь засаж залруулж байсан
- Объект болон ажил үйлчилгээг хүлээн авсан комиссын дүгнэлт буюу акт байсан

Бүлэг 4

Санхүүжилтийн 62.0 хувь оны сүүлчээр хийгджээ

34.1 Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн дийлэнхийг 11, 12 дугаар сард олгожээ

2008 онд Сангийн яамнаас батлан хамгаалах болон хуулийн байгууллагуудад олгосон санхүүжилтийг сар бүрээр тооцож үзэхэд 2008 оны 11, 12 дугаар сард нийт санхүүжилтийн 36.6 хувь буюу 18.7 тэрбум төгрөгийг олгосон нь хөрөнгө оруулалтын ажил оны сүүл рүү шахагдаж хийгддэгтэй холбоотой байна.

4.2 ТЕЗ-дын санхүү, ар талын газар, Хөрөнгө оруулалт барилга захиалагчийн албад хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт тавьсан байна

ЦЕГ, ШШГЕГ-ын Санхүүгийн бодлогын газрын Санхүү, бүртгэлийн хэлтэс санхүүжилтийн асуудлыг, Хангамж, үйлчилгээ, үйлдвэр, барилгын хэлтэс мэргэжлийн хяналт тавьж ажилласан байна. Энэ хэлтэст мэргэжлийн инженерүүд ажиллаж захиалагчийн тавих хяналтыг хэрэгжүүлдэг бөгөөд зарим хяналтыг зургийн автор, мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлжээ.

4.3 Хөрөнгө оруулалтын удирдлага, санхүүжилтийн асуудлыг боловсронгуй болгох шаардлагатай байна

Аудитад хамрагдсан бусад байгууллагын хувьд хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжлийн ажилтан байхгүй, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхийн тулд баригдаж байгаа барилга байгууламжид мэргэжлийн ажилтан түр хугацаагаар авч ажиллуулж байгаа нь хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт тавих боловсон хүчний нөөц бололцоо муу байгааг харуулж байна.

БХЯ, ХХЕГ-ын хөрөнгө оруулалтын бодлого, захиалагчийн хяналтыг Хөрөнгө оруулалт, барилгын алба хариуцан гүйцэтгэдэг бөгөөд энэ алба нь техник хяналтын зардлаар санхүүждэг байна. Хөрөнгө оруулалтын зардал тус газрын Санхүү, бүртгэлийн хэлтсээр дамждаг боловч худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгах, бүртгэлээр тавих хяналт сул, хуурамч гүйцэтгэлээр санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагад олгож байгаа нь Санхүүгийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, барилгын албадын ажил уялдаа холбоогүйг харуулж байна.

Аудитын явцад ХХЕГ-ын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ажилтнуудын дунд явуулсан санал асуулгаар:

- ✓ Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг удирдлагын зүгээс бодитой төлөвлөж чадаж байна уу? гэсэн асуултанд 44 хувь нь үгүй
- ✓ Та тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн ажиллагааг хангалттай гэж үнэлж байна уу? гэсэн асуултанд 61 хувь нь хангалтгүй
- ✓ Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг үнэлэх, хариуцлага тооцох үйл явц хангалттай юу? гэсэн асуултанд 55 хувь нь хангалтгүй

- ✓ Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж буй ажилтнуудын хоорондын ажлын уялдаа холбоо оновчтой, үр нөлөөтэй байна уу? гэсэн асуултанд 66 хувь нь үр нөлөөгүй гэж хариулсан байна.

Дээрх санал асуулгын дүнгээс үзэхэд ХХЕГ-ын Санхүүгийн хэлтэс, Хөрөнгө оруулалтын албаны үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны удирдлага, санхүүжилтийн тогтолцоо оновчтой, үр ашигтай, үр нөлөөтэй зохион байгуулагдсан уу гэсэн асуудлаар БХЯ, ХЗДХЯ, ЦЕГ, УДШ, ШШГЕГ, УЕПГ-аас нийт 97 асуулгын дүнг нэгтгэхэд 29 асуулт буюу 30.5 хувь нь сөрөг, 66 асуулт буюу 69,5 хувь нь эерэг хариулт өгчээ.

Асуулгын дүнгээс үзэхэд хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ бүрээр үе шатны ажилд үр нөлөөтэй байнгын хяналт тавьж чадахгүй, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцдоггүй, тооцох аргачлал боловсруулах шаардлагатай байна.

Сөрөг хариултын дийлэнхийн үндэслэлийг жагсаавал:
➤ Төрийн сангийн газар нь нээгдсэн эрхийн дагуу ажлын 2 хоногт багтаан тухайн төслийг санхүүжүүлээгүй
➤ Барилга захиалагчийн алба аудитын шалгалтад хамрагдаж байгаагүй
➤ Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах боловсон хүчний нөөц боломжийг судалж, тогтоосон баримт материал байхгүй
➤ Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эрхлэн явуулахад хүн хүчний нөөц боломж хангалттай биш
➤ Захиалагч ба гүйцэтгэгч байгууллагын ажилтан гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ биелүүлээгүй
➤ Яамд болон захиалагч зохих журмын дагуу хөрөнгө оруулалтын ажлыг хэрхэн удирдан зохион байгуулсныг үнэлээгүй
➤ Сангийн яам бусад яамд, орон нутгийн хөрөнгө оруулалтын талаар хүлээсэн үүргийн биелэлтийг нарийвчлан хянаагүй
➤ Захиалагч хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр бий болсон хөрөнгийг нягтлан бодох бүртгэл, тайланд үнэн зөв бүртгээгүй
➤ Хяналт, шалгалтыг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үе шат бүрээр, гүйцэтгэл бүрээр тавьж чадаагүй
➤ ХО-ыг бүх эх үүсвэрээр нь нэгтгэн үр өгөөжийг тооцдоггүй
➤ Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцдог тогтсон аргачлал байхгүй

Эерэг хариултын олонхийн үндэслэлийг жагсаавал:
➤ Яам, газар, захиалагчийн барилга объект нэг бүрийн ажлын баталгаажсан гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилтийн эрх нээсэн
➤ Сангийн яам төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний дагуу баримт, материалыг үндэслэн санхүүжүүлэх эрх нээсэн
➤ Гүйцэтгэгч тал бараа, ажил, үйлчилгээгээ цаг тухайд нь нийлүүлсэн боловч санхүүжилт удааширсан тохиолдол байхгүй
➤ Сангийн яам санхүүжилтийг хугацаандаа хийсэн
➤ Хөрөнгийг хууль ёсоор зориулалтын дагуу зарцуулсан
➤ Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьсан
➤ Санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээ, ажлын явцын талаарх мэдээллийг Төсвийн ерөнхийлөн захирагч, яам, газар сар бүр гаргаж өгсөн
➤ Хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна

ДҮГНЭЛТ

Улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт гаргаж байна. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагууд 2008 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зөвхөн улсын төсвийн болон МУХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тусгасан бөгөөд зээл, тусламж, өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөөгүй, хөрөнгийн эх үүсвэрийг бүрэн тусгаагүй байна.
- Захиалагчид худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуульд заасны дагуу нийтэд зарлан мэдээлээгүй, аудитад хамрагдсан ихэнх байгууллага тендерийн урилгыг хамгийн олон уншигчтай өдөр тутмын сонинд хэвлүүлээгүй нь худалдан авах ажиллагааны ил тод, өрсөлдөх тэгш боломжоор хангах зарчмыг алдагдуулж байна.
- Захиалагчид Үнэлгээний хороог байгуулахдаа хуулийн заалтыг зөрчсөн, Төрийн нууцад хамаарахгүй зүйлийг төрийн нууцад хамааруулан хууль зөрчин гүйцэтгэгчийг сонгосон, гэрээнд техникийн нөхцлийг дутуу тусгасан зөрчил нийтлэг байна. Энэ нь Үнэлгээний хорооны гишүүдийн ажил хэргийн болон эрхзүйн мэдлэг, дадлага муу, хариуцлага сулаас шалтгаалжээ.
- Хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, тодорхой шийдвэргүйгээр суудлын автомашин худалдан авсан, зарим төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулж хэрэгжүүлсэн, барилга ашиглалтад хүлээн авсан боловч төсөвт өртгөөс нь дутуу санхүүжүүлсэн, зарим худалдан авалт, хөрөнгө оруулалтын ажилд хуурамч гүйцэтгэл гарган санхүүжилтийг олгосон, улсын комисс хүлээн аваагүй барилгыг ашигласан зэрэг зөрчлүүд илэрлээ.
- Хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн алба, Санхүү, бүртгэлийн хэлтсийн ажлын уялдаа сул, ажилтнуудын ажлын зохион байгуулалт оновчтой биш байна.

Холбогдох байгууллагын санал

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Баярт:

- Худалдан авах ажиллагааны талаархи хууль тогтоомжид төрийн нууцад хамаарах үндэслэлээр шууд гэрээ байгуулан худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээг тодорхой зааж өгөх санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд улсын төсвийн болон МУХС-ийн хөрөнгө, зээл, тусламж, өөрийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрэн тусгах арга хэмжээ авах
- Төрийн байгууллагуудын төвлөрүүлсэн автомашинаас илүүдэлтэй автомашиныг дуудлага худалдаагаар борлуулсны орлогыг ТӨХ зохих шийдвэр гараагүй байхад дур мэдэн зарцуулж байгааг зогсоох

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

- ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэвлэлд нийтлүүлж нийтэд зарлан мэдээлж байх
- Хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох тендерийн урилгыг хамгийн олон уншигчтай сонинуудад тендерийн хэвлүүлж байх
- Орон нутагт хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд захиалагчаас тавих хяналтыг орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах

Монгол Улсын Ерөнхий прокурор М.Алтанхуягт:

- Нийслэлийн прокурорын газрын конторын барилгыг Улсын комиссоор оруулан хүлээн авах
- УЕПГ болон аймгуудын прокурорын газрын барилгуудад хийсэн 294.5 сая төгрөгийн их засварын ажлыг данс бүртгэлд тусгах арга хэмжээ авах

Батлах хамгаалахын сайд Л.Болдод:

- Хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, гэрээнд техникийн нөхцлийг дутуу тусгасан, зарим худалдан авалт, хөрөнгө оруулалтын ажилд хуурамч гүйцэтгэл гарган санхүүжилтийг олгосон албан тушаалтнуудад хариуцлага тооцох
- Төрийн нууцад хамаарахгүй зүйлийг төрийн нууцад хамааруулан хууль зөрчин гүйцэтгэгчийг сонгосон үйл ажиллагааг таслан зогсоох

- Батлан хамгаалах үйл ажиллагаанд худалдан авсан “Камаз-53212” маркийн машиныг тохирох өнгөтэй машинаар солих арга хэмжээ авах
- Гадаадын тусламжийн хөрөнгөөр нийлүүлсэн 9.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгах арга хэмжээ авах
- БХЯ-ны Санхүү бүртгэлийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, барилга захиалагчийн албаны үйл ажиллагааг уялдуулах арга хэмжээ авах
- Хуурамч гүйцэтгэл гарган санхүүжилтийг олгосон Зэвсэгт хүчний 124 дугаар ангийн 1150,0 сая төгрөгийн төсөвтэй 50 айлын орон сууцны барилгыг гүйцээн барьж ашиглалтад оруулах арга хэмжээ авах

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид:

- Хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, зарим худалдан авалт, хөрөнгө оруулалтын ажил дуусаагүй байхад дууссанаар гүйцэтгэл гарган санхүүжилтийг олгосон, худалдан авах ажиллагаанд хариуцлагагүй хандсан албан тушаалтнуудад хариуцлага тооцох
- ХХЕГ-т тусламжийн хөрөнгөөр нийлүүлсэн 3.6 тэрбум төгрөгийн автомашин, тоног төхөөрөмж, бараа материал, Шадар сайдын төсвийн багцаас олгосон 36.7 сая төгрөгийн зураг, төсвийг данс бүртгэлд тусгах арга хэмжээ авах
- ХХЕГ-ын Санхүү бүртгэлийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, барилгын албаны үйл ажиллагааг уялдуулах арга хэмжээ авах

